

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Баяртогтох Дуламханд

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
1	Боловсролын ерөнхий хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	Батлагдсан журам	Журмын төсөл	Журмыг хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, олон нийтэд сурталчлан таниулсан байна.	Боловсролын ерөнхий хуулийн 26.1.4-д заасныг үндэслэн “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам"-ийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Журам батлах тухай" 2024.03.20-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 6772 дугаарт бүргэгдсэн. Энэхүү журам нь 5 бүлгийн хүрээнд хүнс нийлүүлэгч болон хүлээн авагч талын харилцаа, хоолны үйлчилгээний зохион	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгуулалт, хүнс ханган нийлүүлэгчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, шаардлага хангахгүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг буцаах, солих, боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоолны чанарт хяналт тавих оролцоог нэмэгдүүлэх, сургалтын байгууллагын орчинд хоол хүнсний болзошгүй эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх, хүүхдэд тэгш, хүртээмжтэй, шим тэжээллэг хоолоор үйлчлэх, мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагааг зохицуулна. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Боловсролын ерөнхий газарт журмыг боловсролын сургалтын байгууллагад танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Төрийн нарийн бичгийн даргын "Тушаал хүргүүлэх тухай" 2024.04.22-ны өдрийн 2/1625 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Хавсралт: 2 файл		
1.2. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
2	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөлтийг шинэчлэн сайжруулна.	Бодлогын шийдэл хувилбар, төлөвлөлтийн төсөл	Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоол	Аймаг, орон нутаг, нийслэлийн түвшинд бодлогын шийдэл хувилбар, дунд хугацааны төлөвлөгөөний төслийг	Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бүрэн өртгийг тооцож, түүгээр санхүүжүүлэх боломж, шийдлийн талаарх судалгааг Боловсролын үндэсний судалгааны төвийн эрдэмтэн судлаачтай хамтран Орхон аймгийн төрийн өмчийн 16 сургуульд хийсэн. Судалгааны үр	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын

				боловсруулсан байна.	дүнд үндэслэн хоолны зардлыг бүрэн өртгөөр тооцох санхүүжилтийн тооцооллыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, тогтоолын төсөл боловсруулсан. Судалгааны үр дүнд бага ангийн суралцагчийн тооны итгэлцүүр 1 байх үеийн түүхий эд материалын зардлаас бусад өртгийн дүн ус, цахилгааны дүнг оруулан тооцоход нэг хүүхдэд өдрийн 1690 төгрөг, оруулан тооцоогүй үед 1474 төгрөг байна. Нийт өртгийн 46.5 хувь нь гал тогооны ажилтны үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 19.9 хувь нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 2.9 хувь нь ариутгал, үйлчилгээ, аюулгүй байдлын зардалд, 0.9 хувь нь сургалтын зардалд, 0.5 хувь нь эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын үйлчилгээний зардалд, 3.2 хувь нь засварын зардалд 14.6 хувь нь тоног төхөөрөмж, хэрэгслийн нөхөн хангалтын зардалд, 12.8 хувь нь ус, цахилгаан болон эрчим хүчний зардалд хуваарилагдаж байна. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд i) ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бүрэн өртөгөөр санхүүжүүлэх; ii)	сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
--	--	--	--	-----------------------------	---	-----	---

					стандартын шаардлагад нийцсэн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмж нийлүүлэх; iii) хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоо бүрдүүлэх; iv) хүнсний хангамж, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд 12 арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэхэр төлөвлөсөн. Хавсралт: 11 файл		
1.4. Сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах							
3	Орон нутгийн дэмжлэг, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог хангах замаар хүүхдийн хоол, хүнсний хангамж, хүртээмжийг сайжруулна.	Засгийн газрын хуралдаанд танилцуулна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал	Засгийн газрын 2019 оны 450, 2021 оны 207 дугаар тогтоол, 2022 оны 36, 55 дугаар тэмдэглэл, 2022 оны 498 дугаар тогтоол	Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, эцэг эх, асран хамгаалагч хариуцах тухай Засгийн газрын тогтоол, хэрэгжүүлэх аргачлалыг баталж, мөрдүүлнэ.	Засгийн газрын "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2024.05.29-ны өдрийн 237 дугаар тогтоолоор өдрийн хоолны зардлыг 3000/4100 төгрөг болгон нэмэгдүүлж, мөн эцэг эх, асран хамгаалагчаас хоолны зардлын тодорхой хэсгийг хариуцуулах талаар судалж танилцуулахыг Боловсролын сайдад даалгасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2024.9.11-ны өдрийн хуралдаанд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 1000 төгрөгөөр нэмэгдүүлэх, түүнийг эцэг эх, асран хамгаалагчаас санхүүжүүлэх тогтоолын төслийг танилцуулж, "Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоол батлагдсан. Хүүхдийн хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагчаас төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах талаар Боловсролын сайдын "Аргачлал, маягт батлах тухай" 2024.9.12-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын тодорхой хэсгийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих аргачлал"-ыг баталж, 2024.10.1-ны өдрөөс нийслэлд мөрдөж эхэлсэн. Аргачлалыг хэрхэн мөрдөх талаар нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, нярав, нягтлан нарт 2024.9.26-27-ны өдрүүдэд танхимаар, тогооч нарт 2024.10.27-ны өдөр цахимаар танилцуул, хэрэгжүүлэх арга зүйн сургалт хийсэн. Мөн цэцэрлэгийн хоолны үйлчилгээнд цахим систем нэвтрүүлэх Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамж, чиглэлийн дагуу одоогийн байдлаар 4 байгууллагын цахим системийг нийслэлийн төрийн өмчийн 309 цэцэрлэг ашиглаж байна. 2024.10.17-ны өдөр хоолны цахим системийн хэрэглээ, ашиглалт, нэхэмжлэх, гүйцэтгэлд гарч буй асуудлын талаарх сургалтыг дүүргийн Боловсролын хэлтсийн хоол, СӨБ хариуцсан		
--	--	--	--	--	--	--	--

					арга зүйч нарт зохион байгуулсан. 2024 оны 10 дугаар сард 96808 хүүхдийн хоолны зардлыг эцэг эхээс төвлөрүүлж, 42893 хүүхдийн хоолны зардлын зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна. 11 дүгээр сарын тайлан 12 дугаар сарын 10-ны өдөр эцэслэгдэж гарна. Хавсралт: 7 файл		
4	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шаардлагад нийцүүлж, сурагчдад сургууль дээр шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	Стандартын шаардлага хангасан сургууль, цэцэрлэг, шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангагдсан сургуулийн эзлэх хувь	Стандартын шаардлага хангасан сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь 50.8 хувь Шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангагдсан сургуулийн эзлэх хувь 57.7 хувь	Стандартын түвшин тогтоох үнэлгээг хийсэн байна. Стандартын шаардлага хангасан болон шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангагдсан сургууль, цэцэрлэгийн эзлэх хувийг 70 хувьд хүргэсэн байна.	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандартын үнэлгээ хийх ажлын удирдамж, үнэлгээний асуулгын төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн. Стандартын үнэлгээнд өмчийн хэлбэр харгалзахгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар, дотуур байрын гал тогоог 2025 онд бүрэн хамруулж, үнэлнэ. Стандартын үнэлгээний асуумжийг i) барилга байгууламж; ii) хоол үйлдвэрлэлийн газрын зохион байгуулалт; iii) хоол үйлдвэрлэлийн технологи, үйл ажиллагаа; iv) хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж; v) хүний нөөцийн хүрэлцээ, хэрэгцээ; vi) нэгдсэн нэгтгэл гэсэн зургаан хавсралттайгаар боловсруулсан. Стандартын үнэлгээг улсын хэмжээнд орон нутгийн Боловсролын газраас	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 0%

					хоол хүнсний болон салбарын хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн нар гүйцэтгэж, БЕГ-ын Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс үнэлгээг нэгтгэж, Боловсролын яаманд ирүүлнэ. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандартыг хэрэгжүүлэх зөвлөмжийн төслийг стандартын бүлэг бүрээр боловсруулсан бөгөөд үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тусгах, сайжруулахаар ажиллаж байна. Боловсролын салбарын 2024-2025 хичээлийн жилд 885 сургуулиас хоол үйлдвэрлэлийн газартай 702 сургууль, үүнийг 38 нь тусдаа барилгад, 664 нь хичээлийн үндсэн барилгад байрласан. 702 хоолны газраас 460 (65,5%) нь стандартын шаардлагад нийцсэн, 242 (35%) нь стандартын бус анги танхимыг тохижуулан хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлж байна. Сургуульд нийт 9166 ширхэг ус цэвэршүүлэгч төхөөрөмж байгаагаас 5909 ширхэг нь баллонтой ус цэвэршүүлэгч төхөөрөмж (ангид 5197 ширхэг, коридорт 712 ширхэг) байна. 3257 ширхэг шугамд холбогдсон ус цэвэршүүлэгч төхөөрөмж (1357 ширхэг нь ангид, 1900 ширхэг нь коридорт) байна. Нийт сургуулийн 86% нь ус цэвэршүүлэгч		
--	--	--	--	--	---	--	--

					төхөөрөмжөөр хангагдсан, 87 хүүхдэд (MNS 6782:2019 стандартад 75 хүүхдэд 1 төхөөрөмж) нэг ус цэвэршүүлэгч төхөөрөмж ноогдож байна. Хавсралт: 3 файл		
5	Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг сайжруулж, чадавхжуулна.	Хүний нөөцийн норматив, стандарт Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	-	Ажил мэргэжлийн стандартыг батлуулж, хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний сургагч багшийг бэлтгэсэн байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын "Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай" 2024 оны А/85, А/34 дүгээр хамтарсан тушаалаар цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарын жишиг нормативаар 3-17 бүлэгтэй цэцэрлэгт 1-2 тогооч, 1-3 туслах тогооч ажиллахаар баталсан. Сургуулийн багш бус ажилтны орон тооны нормативын төсөлд үдийн хоолонд хамрагдаж буй 200 суралцагч тутамд 1 тогооч, 1 туслах тогооч байхаар саналаа СХОГ-т хүргүүлээд байна. Хоолзүйчийн ажил мэргэжлийн стандартын төслийг боловсруулан мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн, бүрэлдэхүүн Засгийн газрын Засгийн газрын 2024 оны 69 дүгээр тогтоолоор шинэчлэгдэж, хуралдаан хийгээгүй байна. Хуралдаан нь жилд 2 удаа хийх дүрэмтэй. Койка Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн хоолзүйч, тогоочийг давтан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					сургах, чадавхыг дээшлүүлэх сургалт арга зүйн төв байгуулах тушаалын төслийг боловсруулан, танилцуулж байна. Төслийн хүрээнд төвийн үйл ажиллагаа 2024 онд эхэлж 197 сургагч багшийг бэлтгээд байна. Энэхүү сургалт арга зүйн төв нь боловсролын сургалтын байгууллагаар бэлтгэгдсэн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүний нөөцийн хөгжлийг тасралтгүй хангах, тэднийг чадавхжуулах, боловсролын үйлчилгээнд оролцогч талуудад хоол, шим тэжээлийн боловсрол мэдлэг олгох үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий сургалтын байгууллага байна. сургалт арга зүйн төвөөр дамжуулан боловсролын сургалтын байгууллагын суралцагч, багш, ажилтны зохистой хооллолт, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл ахуйн чанар, аюулгүй хоол, үйлчилгээний орчны менежментийг бүрдүүлэх, хоол, шим тэжээлийн боловсрол олгох сургалт, зөвлөгөө, зөвлөх үйлчилгээг цогцоор нь авч хэрэгжүүлэх юм. Түүнчлэн сургалтын цахим контент хөгжүүлэх, ашиглалт хэрэглээг дэмжих, тогтвортой үйл ажиллагааг хангах, эрдэмтэн, судлаач, оюутнуудад дэвшилтэд технологид суурилсан сургалт, судалгаа шинжилгээний ажил		
--	--	--	--	--	---	--	--

					эрхлэх боломж бүрдүүлэх болно. Хавсралт: 6 файл		
1.3. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах							
6	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийж, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл	Хуулийн хэрэгжилтийн үнэлгээ	Хуулийн үзэл баримтлалын төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, ХХААХҮЯ-д хүргүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2024.4.9-ны өдрийн 1а/1392 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Боловсролын ерөнхий хуультай нийцүүлэх, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нэмж тусгах, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хангамжийг төр, хувийн хэвшил хамтран хүртээмжтэй, тасралтгүй тогтвортой үнээр хангах нэгдсэн төвийг орон нутагт байгуулах, нэг сурагчид ноогдох хоолны бүрэн өртөг /түүхий эдийн зардал, хүний нөөцийн цалин, хөлс, тоног төхөөрөмжийн нөхөн хангалт, хоолзүйч, тогоочийн тасралтгүй хөгжлийн зардал/-ийг тооцож, санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх асуудлыг тусгахаар холбогдох тооцоо судалгаа, үр дагаврыг тооцон хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан. Хуулийн нэмэлт өөрчлөлт оруулснаар сургуулийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					суралцагчийн хоол хүнсний хангамж, хүртээмжийг сайжруулах, шим тэжээлийн тэнцвэртэй хоол, хүнсээр тэгш хангах эрхзүйн орчныг бүрдүүлэх, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, газар, тариалан эрхлэгчдийг дэмжих замаар орон нутгийн хөгжлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийн болон эдийн засгийн үзүүлэлтэд эерэг үр дагавар бий болох болно. Хавсралт: 2 файл		
3.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах							
7	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна.	Сургалтын байгууллагын хоол хүнсний хангамж, үйлчилгээнд мөрдөх журмыг орон нутгийн Боловсролын асуудал эрхэлсэн байгууллага болон сайтад байршуулж санал авч, нэгтгэн, сайжруулж, батлуулсан. Хоолны зардлыг нэмэгдүүлэх боломж, шийдлийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалгчийн төлөөлөлийг оролцуулан хэлэлцүүлж, санал шийдлийг тусган ЗГ-ын хуралдаанд танилцуул, тогтоол гарсан. Мөн хэлэлцүүлэгээс гарсан зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагад албан бичгээр хүргүүлсэн. https://moe.gov.mn/post/133717	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судална.	Эрхэлсэн ажлын чиг үүрэгт хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлах, мэдээлэлийн сан бүрдүүлнэ.	9 хууль, 3Г-ын 6 тогтоол, 5 стандарт, 5 журам, 2 жагсаалт, 2 норматив.	Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр (тоогоор)	Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ-2020 онд гарсан номоос MNS27005:2023 стандартын үнэлгээ хийхэд баримтлах зарчим, шалгуур үзүүлэлтийг хэрхэн томъёолох талаар, Хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, удирдлагын тогтолцоо-2024 онд гарсан номоос хүнсний салбарын хүний нөөц, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагын чадавхад хийсэн шинжилгээг, Монгол Улсын хүнсний хангамж, аюулгүй байдал ба шинэ бодлого-2023 онд гарсан номоос бодлогын хувилбарын шинжилгээ бүлгийг уншиж эрхэлсэн ажлын хүрээнд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					боловсруулж буй баримт бичигтээ тусган ажиллаж байна. Хүнсний салбарын хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн үзэл баримтлал боловсруулахад эрхэлсэн ажлын хүрээнд тооцоо, судалгааг хийж байна. Хавсралт: 6 файл		
2	Байгууллага болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалт, мэдээллийн цагт бүрэн хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлнэ.	Байгууллага, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах дунд, богино хугацааны сургалтад танхимаар болон цахимаар хамрагдана.	-	Сургалтад хамрагдаж, сертификат авсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд 2024 оны 5.27-6.04 өдрүүдэд БНСУ-д зохион байгуулагдсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тогтолцоо, хүний нөөцийг чадавхжуулах сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулан шим тэжээлийн боловсрол олгож буй талаар туршлага судлах сургалт, Булган аймгийн Дашинчилэн сумын сургуульд зохион байгуулагдсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, туршлага солилцох сургалт, Хоол үйлдвэрлэлийн чиглэлд оролцоотой Төрийн албан хаагчийг чадавхжуулах	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					сургалтад тус тус хамрагдсан. Мөн 2024 оны 10.23-2025.2.5 хүртэл Төрийн албан хаагчийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байна. Байгууллагын зүгээс зохион байгуулагдсан мэдээллийн цагт бүрэн хамрагдсан. Хавсралт: 3 файл		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Баяртогтох Дуламханд /...../ Огноо: